



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2008 оны 3 дугаар сар

Сэтгүүлчид эрчим хүч, дулааны асуудалтай газар дээр нь танилцлаа

Улаанбаатар хот. 3 дугаар сарын 12-ний өдөр Улаанбаатар Дулааны сүлжээ ХК өдөр тутмын 11 сонин хэвлэл, үндэсний радио ба телевизийн 2 сувгийн сурвалжлагч, сэтгүүлчдэд зориулсан нээлттэй өдөрлөг, семинарыг тус төслийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

Энэ үеэр дулааны сүлжээний өнөөгийн байдал, Улаанбаатар хотын хүн амын өсөлт, барилгын салбарын эрчимтэй хөгжил зэрэгтэй холбогдуулан цаашид үүсэх цахилгаан, дулааны хэрэгцээ, дулааны үнэ, тарифтай холбоотой асуудлаар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв.



УБ Дулааны сүлжээ төрийн өмчит хувьцаат компани нь 2, 3, 4 дүгээр дулааны цахилгаан станцуудад үйлдвэрлэсэн дулааныг Улаанбаатар хотын хэмжээнд дамжуулж, түгээдэг. Тус сүлжээний дулаан дамжуулах хүчин чадал дээд цэгтээ хүрээд байгаа тул дулааны шугам сүлжээнд шинээр хэрэглэгч холбох хэрэгцээг цаашид хангах боломжгүй болж байна. Дулааны сүлжээнд шинэ хэрэглэгч холбох хэрэгцээ жилд 13%-аар өсч байна гэсэн тооцоо бий.

Төвийн сүлжээний шугамын 70 орчим хувийнх нь ашиглалтын хугацаа (хоолойг ашиглах хугацаа 30 жил байдаг) дуусчихсан эсвэл дуусах дөхөж байна. Иймд дулаан түгээх сүлжээ, дулаан үйлдвэрлэх шинэ эх үүсвэр байгуулахад хөрөнгө оруулалт хийхгүй бол 2011 оноос хойш Улаанбаатар хотыг дулаанаар хангах асуудал баталгаагүй болох магадлалтай байна.

Дулааны алдагдал зөвхөн нийлүүлэлтийн шугамд бус мөн эцсийн хэрэглэгчдийн талд үүсдэг байна. Дулааны шугамд дур мэдэн өөрчлөлт хийх, барилгын нэгдүгээр давхрын дулааны шугамыг өргөтгөх, цонх, хаалганы дулаалгыг зөв зохистой хийдэггүй зэрэг шалтгаанаар хэрэглэгчид дулааны алдагдалд нөлөөлдөг тухай сэтгүүлчид мэдэж авлаа.

Өвлийн улиралд халаалт хангалтгүй байдаг шалтгаан, шинэ барилгуудыг дулааны сүлжээнд холбох мөн сүлжээний

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

өнөөгийн нөхцөл байдлын талаар сэтгүүлчдийн тавьсан асуултад УБДЦС ХК-ийн удирдлага хариуллаа. Үүнээс гадна уулзалтад оролцогсод Хан-Уул дүүргийг дулаанаар хангадаг дэд станцад очиж үйл ажиллагаатай нь танилцав.

Даланзадгад. Олон нийтийн хэвлэл мэдээллийн 11 хэрэгслийн 13 сурвалжлагч, сэтгүүлчид 3 дугаар сарын 28-нд Өмнөговь аймгийн Даланзадгад хотод зочилж, 2000 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй Дулааны цахилгааны станцад (ДЦС) гарсан техникийн болон үйл ажиллагааны доголдолтой танилцлаа.

2000 онд Өмнөд Солонгосын Засгийн газрын 9.3 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр баригдсан Даланзадгадын ДЦС-ын үйл ажиллагаа байнга доголдож, тус аймгийн Даланзадгад хот, 5 сумын цахилгаан тасалдаад байгаа билээ.

Уг цахилгаан станц нь 2000-2007 оны хооронд янз бүрийн шалтгаанаар 173 удаагийн тасалдал гарсан байна. Энэ станцыг хоёр зуухтай бөгөөд нэгийг нөөцөд байлгаж нөгөөг нь ашиглах зориулалтаар барьжээ. Гэвч 2008 оны 3 дугаар сарын эхнээс хоёр зуух хоёулаа ашиглалтаас гарсан учраас станц маш хүнд байдалд ороод байна. Дотоод хэсгийг нь 5,000 кКал/кг-ын илчлэгтэй нүүрс хэрэглэхээр тооцоолж барьсан боловч өнөөгийн байдлаар Таван толгойн уурхайгаас нийлүүлж буй ойролцоогоор 5,300-5,800 кКал/кг-ын дулааны илчлэгтэй нүүрс түлсний улмаас зуухны төмөр металл хайлж эвдрээд байна. Станцыг барих явцад тоног төхөөрөмжийн суурилуулалт технологийн шаардлага бүрэн хангаагүй, мөн мэргэжлийн ур чадвар сайтай инженер, ажилчид илүү өндөр цалинтай Таван толгой, Оюу толгой зэрэг ойролцоох уурхай руу шилжин ажиллах болсны улмаас мэргэжлийн ажиллах хүчин дутмаг болсон зэрэг нилээд олон хүчин зүйлс цахилгаан станцад доголдол гарахад нөлөөлж байна.



Цахилгаан, халаалт тасалдах үед тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар сэтгүүлчид орон сууцны оршин суугчид, бизнес эрхлэгчид, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн удирдлагуудтай уулзаж ярилцлаа.

Сэтгүүлчид Даланзадгадад ажиллах томилолтоо дуусах үеэр буюу 3 дугаар сарын эцсээр сүүлийн хэдэн жил ороогүй их хэмжээний цас Даланзадгадад орохын өмнөх өдрүүдэд

сурвалжлагчид цахилгаан, халаалт тасалдахын зовлонг биеэр амсав.

Улаанбаатар, Даланзадгад хотуудад зохион байгуулсан дээрх сургалт семинар нь Түлш, эрчим хүчний яам (ЭХЯ), Эрчим хүчний зохицуулах газраас (ЭХЗГ) өнгөрсөн зун эхлүүлсэн эрчим хүчний асуудлаар олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх кампанит ажлын нэг хэсэг юм.

Замын-Үүдэд ложистик үйл ажиллагаа явуулах нөхцөл байдлын талаар хийх техник, эдийн засгийн судалгаа

Уг төслөөс Тээвэр, худалдааг хөнгөвчлөх үндэсний хороонд (ТХХҮХ) үзүүлж буй техникийн туслалцаагаа үргэлжлүүлэн энэ оны 3 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд ЭЗБШӨЧ төсөл, Гаалийн ерөнхий газар (ГЕГ)-ын хамтарсан баг Замын-Үүд,



Эрээн хотуудад зочилж, гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт, бараа шилжүүлэн ачих явц, нөхцөл байдалтай танилцлаа.

Асуудал ба бэрхшээл:

- Хэдийгээр Замын-Үүдийг Монгол Улсын хилийн "гарц" эсвэл "хуурай газрын боомт" гэж нэрлэдэг ч эдийн засаг, геополитикийн ач холбогдолтой харьцуулахад хөрөнгө нөөцийн хувьд бодит байдал дээр анхаарал бага тавьж байна. Харин БНХАУ нь Замын-Үүдтэй хил залгаа орших хилийн боомт болох Эрээн хотыг Монгол Улс, бусад улсуудтай худалдаа хийх, бараа шилжүүлэн ачих төв болгон цэцэглүүлэн хөгжүүлж байна.
- Монгол Улсын хөгжил нь Замын-Үүдийн гарцаар дамжиж буй импорт, экспорт, дамжин өнгөрөх тээврийн үйл ажиллагааг хэрхэн үр ашигтай зохицуулж, орлого олж буй байдлаас хамаарна.
- Импорт, экспорт, транзитын үйл ажиллагааг үр ашигтай зохицуулж, орлогыг нэмэгдүүлэхэд тулгарч буй бэрхшээл (ач холбогдлын дарааллаар):
 1. УБТЗ-ын зүтгүүр, хөдлөх бүрэлдэхүүний тоо хангалтгүй; уг асуудлыг өөр төслийн хүрээнд энэхүү анализ шинжилгээний цар хүрээнээс гадуур авч хэлэлцэнэ.
 2. Барааг замаас төмөр зам руу шилжүүлэн ачих нөхцөл байдал, зохицуулалт хангалтгүй.
 3. Гаалийн бүрдүүлэлт явуулах нөхцөл боломж хангалтгүй.

Дор дурьдсан хоёр арга хэмжээний стратегийн гол зорилт нь Замын-Үүдийг бусад улс орон руу гарах орчин үеийн гарц болгон хөгжүүлэхэд оршино. Эдгээр арга хэмжээ нь дараахь зорилтыг тавьж байна. Үүнд:

1. Трансакцийн нийт зардлыг багасгах буюу өөрөө хэлбэл бараа бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлт, шилжүүлэн ачих үйл ажиллагааны үр ашиг, үр өгөөжийг дээшлүүлэх
2. Хяналт шалгалтыг хөнгөвчилж, үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах

Доорх хоёр тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд:

- Замын-Үүд дэх гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээ (ГЕГ ба Улсын Мэргэжлийн хяналтын газар) нэвтрүүлэх
- Авто замаас төмөр замд, төмөр замаас төмөр замд барааг шилжүүлэн ачих шинэ нөхцлийг бүрдүүлэх

Замын Үүд дээрх гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээ

Дараахь байдлаар төрийн байгууллагуудын хяналт шалгалтын ажиллагааг сайжруулж, чадавхийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Ачаа тээврийг зорчигч тээврээс салгах
- Ачааны машины эргэлт, хяналт шалгалтыг хөнгөвчлөх нөхцлийг сайжруулах
- Худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхны хөтөлбөрөөс тавьж буй шаардлагатай уялдуулан Улсын Мэргэжлийн хяналтын газар (УМХГ)-ыг ГЕГ-тай холбож компьютержүүлэх
- Эрсдэлийн менежментийн систем, ГЕГ-УМХГ-ын хамтарсан хяналтыг хэрэгжүүлэх

Гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөх дэд бүтцийн тусгай бүрэлдэхүүн хэсэгт дараах зүйлс багтана. Үүнд:

- Ачааны машиныг хил нэвтрүүлэхэд зориулсан тусгай шинэ зам
- Өргөтгөж, шинэчлэсэн машины зогсоол, хяналт шалгалтын талбай
- Салбар зам гаргаж өөрчлөн шинэчлэсэн ерөнхий гол зам
- Ачааг дэлгэж шалгахад зориулсан талбай
- Рентгенд хүргэх дотоод тусгай зам
- Ачааны машин жинлэх хоёр дахь жинлүүрийн боломж (шийдвэрлэх)
- Ачааны машины хоёр дахь рентген (шийдвэрлэх)

Барааг авто замаас төмөр замд шилжүүлэн ачих шинэ терминал

Хил дээр гаалийн бүрдүүлэлт хийж, хяналт шалгалтаар орсон ачааг шилжүүлэн ачих үйл ажиллагааг сайжруулж хүчин чадлыг нь өргөжүүлэхийн тулд юуны өмнө барааг авто замаас төмөр замд шилжүүлэн ачих шинэ терминалыг бий болгох шаардлагатай байна. Энэ үйл ажиллагааг эхлүүлэхэд энэхүү зорилгод одоогоор ашиглаж буй талбайг Төмөр замаас Төмөр замд ачааг шилжүүлэн ачиж байгаа байгууламжийг өргөжүүлэхэд ашиглаж болох юм.

Үүнд наад зах нь дараахь нөхцөл шаардагдана. Үүнд:

- Урт хугацаанд үе шаттай хөгжүүлэх 200 га талбайг албан ёсоор хадгалж нөөцлөх
- Замын-Үүд ба Улаанбаатарыг холбох өндөр хүчин чадлын хурдны авто замын коридорыг байгуулах
- Барааг замаас төмөр замд шилжүүлэн ачиж, буулгах талбай бүхий өргөжүүлэх боломжтой төмөр замын туслах замын сүлжээ
- Гүүрэн кран, сэрээт ачигч машин зэрэг бараа шилжүүлэн ачих иж бүрэн тоног төхөөрөмжүүд
- Хүнд даацын ачааны машинд зориулсан автозамын дотоод эргэлтийн үр ашигтай сүлжээ
- Ачааны машинд ачаа ачих/буулгах талбай бүхий агуулах (тусгайлсан болон аль болох тохиромжтойгоор байгуулсан).

Тус төслийн шугамаар ажиллаж буй ложистикийн мэргэжилтэн Майкл Бенеттийн туслалцаатайгаар Замын-

Үүдийн хил дээр худалдаа, тээврийн ложистик үйл ажиллагаанд гарч буй гол хүндрэл бэрхшээлүүд, тэдгээрийг шийдвэрлэх зорилгоор хэрэгжүүлэх төсөл, авах арга хэмжээ болон үйл ажиллагааны хуваарь зэргийг тусгасан техникийн тайланг уг төслөөс 4 дүгээр сард бэлэн болгохоор төлөвлөж байна.

Дамжин өнгөрөх тээврийн харилцааны талаар үндэсний семинар боллоо

2008 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Тээвэр, худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо (ТХХҮХ)-ноос "Монгол Улсын дамжин өнгөрөх тээврийн харилцааны зохицуулалтын хүрээ" сэдвээр үндэсний семинар зохион байгууллаа. Энэхүү семинарын зорилго нь дамжин өнгөрөх тээврийн харилцааны зохицуулалтын хүрээний талаар ЭЗБШӨЧ төслөөс хийсэн дүн шинжилгээ, ялангуяа "Дамжин өнгөрөх тээврийн тухай БНХАУ, Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын гурван талт хэлэлцээр"-ийн төслийг тусгайлан онцолж танилцуулахад оршиж байв.



Семинарт нийтдээ 54 хүн оролцсоны дотор УИХ-ын гишүүн, Зам тээвэр, аялал жуулчлалын сайд, Худалдаа, тээврийн хөнгөвчлөх үндэсний хорооны дарга Р. Рааш, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах түшмэл х. Буяндэлгэр нар байв. Гадаад хэргийн яам (ГХЯ)-ны Гэрээ, эрх зүйн газрын дарга С. Алтангэрэл, Зам, тээвэр, аялал жуулчлалын яам (ЗТАЖЯ)-ны Тээврийн хэлтсийн дарга Д. Наранпүрэв, Үйлдвэр, худалдааны яам (ҮХЯ)-ны Худалдааны бодлогын газрын дарга В. Энхболд нар семинарыг удирдан явуулав.

Семинарт гурван талт хэлэлцээрийн төслийн Засгийн газрын Ажлын хэсгийн гишүүдээс гадна Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ЗТАЖЯ, ҮХЯ, Гаалийн ерөнхий газар (ГЕГ), Хилийн цэргийн удирдах газар, Улсын Мэргэжлийн хяналтын газар (УМХГ), Төмөр замын хэрэг эрхлэх газар, Улаанбаатар төмөр зам, Монголын Үндэсний Худалдаа, аж үйлдвэрийн танхим, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцлоо.

Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Р. Рааш хэлсэн нээлтийн үгэндээ Монгол Улсын хувьд дамжин өнгөрөх тээврийн ач холбогдлыг онцолж, судлаачид болон энэ үйл ажиллагаанд оролцогч-бизнесийн томоохон байгууллагуудтай уг асуудлыг ярилцан хэлэлцэх Монгол Улсын Засгийн газрын анхны оролдлого болж байгааг тэмдэглэсэн юм.

ГХЯ болон ЭЗБШӨЧ төслөөс дараахь презентацийг тавилаа. Үүнд:

- "Дамжин өнгөрөх тээврийн зохицуулалтын хүрээ: Харьцуулсан судалгаа"
- "Дамжин өнгөрөх тээврийн тухай БНХАУ, Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн явц, өнөөгийн байдал
- "Хэлэлцээрийн төслийн одоогийн хувилбар нь Монгол Улс өөрийн зорилгодоо хүрэх боломжийг бүрдүүлэх үү?"

ЭЗБШӨЧ төслийн презентаци нь дараахь асуудлуудад чиглэсэн байв. Үүнд:

- Тээвэр, худалдааг хөнгөвчлөх талаархи олон улсын дамжин өнгөрөх тээврийн гэрээ хэлэлцээрийн олон улсын туршлага
- Далайд гарцгүй орны хувьд Монгол Улс өөрийн статусыг ашиглаж болох арга хэрэгслүүд
- Хэлэлцээрийн одоогийн төсөлд орсон заалт, нөхцлүүдээс гарч болох үр дагавар
- Хэлэлцээрийн зорилгод нийцсэн тодорхой заалт, нөхцлүүдтэй холбоотой зарим асуудлууд.

Үдээс хойшхи семинарт оролцогчдыг тусгайлсан сэдвээр бүлгүүдэд хувааж, судалгаа, суралцсан зүйлээрээ санал өгөх, зөвлөмж гаргах чиглэлээр ажиллуулсан бөгөөд эдгээрийг Ажлын хэсэгт зөвлөмж болгохоор цуглуулж нэгтгэсэн юм.

Семинарын оролцогчид хэлэлцээрийн төслийг боловсруулахдаа Монгол Улсад аль болох өгөөжтэй байх талаас нь анхаарч боловсруулах, мөн энэ төсөлд олон улсын шинжээчийг ажиллуулах хэрэгцээ байгааг онцоллоо.

Төслийн зүгээс Ажлын хэсэг, ТХХҮХ, ГХЯ-д хэлэлцээрийн төслийн техникийн хавсралтуудын төслийг боловсруулахад туслалцаа үзүүлж байна. ТХХҮХ, Монгол Улсын Засгийн газраас энэхүү хэлэлцээрийг байгуулах нь БНХАУ, Европыг холбох дамжин өнгөрөх гарц болох Монгол Улсын өрсөлдөх чадварыг хөгжүүлэх ж, үйлчилгээний салбараас их хэмжээний нэмэлт орлого олоход туслах "тулгын чулуу" болно гэж үзэж байна.

Берлин хотноо болсон Олон улсын аялал жуулчлалын ИТБ 2008 үзэсгэлэн яармагт Монголын төлөөлөгчид оролцлоо



Зам, тээвэр, аялал жуулчлалын яам (ЗТАЖЯ), Үндэсний Аялал жуулчлалын байгууллага (ҮАЖБ)-ын хүсэлтийн дагуу ЭЗБШӨЧ төслийн туслалцаатайгаар Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармаг ИТБ 2008-д дотоодын аялал жуулчлалын компаниудыг оролцуулах арга хэмжээг 3 дугаар

сарын 4-9-ний өдрүүдэд зохион байгуулав. ИТБ нь Берлин хотноо жил бүр зохион байгуулагддаг дэлхийн аялал жуулчлал, худалдааны хамгийн том үзэсгэлэн яармаг юм.

Уг үзэсгэлэн яармагт аялал жуулчлалын үндэсний дөрвөн тур оператор, агаарын тээвэр, үндэсний парк, зочид буудал, автомашины түрээсийн компанийг төлөөлөн Монгол Улсын аялал жуулчлалын салбарын 11 компани нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцов.

ҮАЖБ нь ИТБ-д оролцох бэлтгэл ажлыг хангасны зэрэгцээ хэвлэлийн бага хурал, Монголын соёлын арга хэмжээг зохион байгуулж, үүнд хэвлэл мэдээллийн 25 байгууллагын төлөөлөгчид оролцсон бөгөөд өгсөн ярилцлага, арга хэмжээний талаар ХБНГУ-ын хэвлэл мэдээллийн гол хэрэгслүүдээр цацагдсан юм.

Мортгэйжийн хоёрдогч зах зээлийн эрх зүй, зохицуулалтын талаар дугуй ширээний ярилцлага болов

3 дугаар сарын 15-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ), Санхүүгийн зохицуулах хороо ЭЗБШӨЧ төслийн



туслалцаатайгаар "Мортгэйжийн хоёрдогч зах зээлийн эрх зүйн болон зохицуулалтын орчин" сэдвээр дугуй ширээний ярилцлага зохион байгуулав.

Амралтын өдөр болсон энэхүү дугуй ширээний ярилцлага нь дараахь зорилготой байлаа. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан өрийн бичгийн тухай, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслийн ойлголтыг нэгтгэх замаар барьцаалах, үнэт цаасжуулах эрх зүйн болон зохицуулалтын зохистой хүрээг бий болгох
- Орон сууцны санхүүжилтийн болон хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих
- Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэгдэх арилжигдах үнэт цаасыг нэвтрүүлэх талаар ярилцах

Амралтын өдрийн энэхүү арга хэмжээ нь ХЗДХЯ-аас үнэт цаасжилтын тухай хуулийн төслүүдийг яамд, Засгийн газрын агентлагуудаар хянуулж, санал авахаар тойруулахаас өмнө тэдний хооронд хэлэлцүүлэг өрнүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болсон юм.

Ярилцлагад УИХ-ын гишүүн, Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай хуулийг хэлэлцүүлэх УИХ-ын Ажлын хэсгийн ахлагч З. Энхболд, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны дарга Д. Баярсайхан нар оролцов. Энэхүү арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн яамны дэд сайд М. Төрбаяр удирдаж явууллаа. Ярилцлагад Орон сууц санхүүжилтийн корпораци (ОССК), МИК-ийн гүйцэтгэх захирлууд, СЗХ-ны ажилтнууд, Дээд шүүхийн хуульчид, яамдын хуулийн ажилтнууд оролцов.

ХЗДХЯ, СЗХ, ЭЗБШӨЧ төсөл, МИК дараахь сэдвүүдээр презентаци тавилаа. Үүнд:

- Мортгэйжийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхэд Засгийн газрын гүйцэтгэх үүрэг
- Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан өрийн бичгийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслүүдийн танилцуулга
- Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нэвтрүүлэх замаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжүүлэх нь
- Монголын Ипотекийн корпорацийн (МИК) үүрэг, шаардлагатай эрх зүйн орчин

Ноён Д. Баярсайхан хэлсэн нээлтийн үгэндээ орон сууцны санхүүжилтийг сайжруулах, мортгэйжийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх, үүний дотор эрх зүйн болон зохицуулалтын орчин, орон сууцны татаас, нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн тогтолцооны шинэчлэл, мортгэйжийн хоёрдогч зах зээлийн хөрөнгө оруулагчдад зориулсан хөнгөлөлт, зохицуулалтад Засгийн газраас бодитой үүрэг гүйцэтгэж чадах чиглэлүүдийг онцолсон юм.

УИХ-ын гишүүн, Үл хөдлөх хөрөнгө барьцаалах тухай хуулийг хэлэлцүүлэх УИХ-ын Ажлын хэсгийн ахлагч З. Энхболд эдгээр хуулийн ач холбогдлыг өөрийн саналдаа онцлон дурьдаад АНУ-д тулгарч буй мортгэйжийн зах зээлийн хямралтай холбогдуулан эдгээр хуулийн төсөлд илүү анхааралтай хандах шаардлагатайг онцоллоо.

ЭЗБШӨЧ төслийн презентацид хөрөнгийн зах зээлээс урт хугацааны мортгэйжийн санхүүжилтийг босгоход нийтлэг байдлаар ашигладаг барьцаат мортгэйжийн бондын Европын загвар, орон сууцны мортгэйжээр баталгаажсан үнэт цаас гэсэн санхүүгийн хоёр хэрэгсэл, тэдгээрийн адил болон ялгаатай талууд, бусад улс орнуудын туршлагад голлон төвлөрч байсан юм.

СЗХ-ны гишүүн бөгөөд дэд дарга Д. Дүгэржав барьцаалах, үнэт цаасжуулалтыг нэвтрүүлэхэд хувийн хэвшил давамгайлсан өрсөлдөөнд орчныг бий болгох, зохицуулах зорилготой Үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан өрийн бичгийн тухай болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн төслийн талаар презентаци тавилаа. Эдгээр хууль хүчин төгөлдөр үйлчилснээр мортгэйжийн зээл олгогч байгууллагууд, санхүүгийн компаниуд өөрсдийн санхүүжилтийн хэрэгцээндээ хоёрдогч зах зээлийн хэрэгслүүдээс хамгийн тохиромжтойг нь сонгох боломжтой болно. Нөгөөтэйгүүр дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид аль аль нь одоогоор нэвтрэх боломжгүй байгаа Монгол улсын мортгэйжийн ашигтай зах зээлд хөрөнгө оруулах боломж олгох юм.

ХЗДХЯ-аас мортгэйжийн хоёрдогч зах зээлийг цаашид тогтвортой хөгжүүлэх, ялангуяа үнэт цаасжилтын эдгээр шинэ хуулиудтай холбоотойгоор бусад хууль, тогтоомж, журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэлээ.

ЭЗБШӨЧ төслийн зүгээс үнэт цаасжуулалт, мортгэйжийн хоёрдогч зах зээлийн эрх зүйн болон зохицуулалтын орчинг бүрдүүлэх чиглэлд СЗХ-ноос хийж гүйцэтгэж буй ажил, хүчин чармайлтыг дэмжиж, туслалцаа үзүүлж байна.

Эрчим хүчний зохицуулах газар тусгай зөвшөөрөлтэй хоёр компанитай Гүйцэтгэлийн гэрээнд гарын үсэг зурлаа

Эрчим хүчний зохицуулах газар (ЭХЗГ)-аас 2008 оны 3 дугаар сард тусгай зөвшөөрөл бүхий хоёр компани, тухайлбал Дарханы Дулааны цахилгаан станц (ДЦС), Багануур, Зүүн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ (БЗӨБЦТС)-тэй хэлэлцээр хийж Гүйцэтгэлийн гэрээнд гарын үсэг зурлаа. Эдгээр хоёр гэрээ нь ЭХЗГ-аас БЗӨБЦТС-тэй байгуулж амжилттай хэрэгжсэн эхний ГГ-ний загвараар хийгдсэн юм.

ДЦС-ын Гүйцэтгэлийн гэрээнд үр дүнгийн гол үзүүлэлтүүдэд дараахь үзүүлэлтүүд орж байна. Үүнд:

- Эргэлтийн харьцаа (төлбөрийн чадавхийн илэрхийлэл)
- Хэрэглэгчдээс авлага цуглуулах дундаж хугацааг сайжруулсан байдал
- Өглөг барагдуулах дундаж хугацааг сайжруулсан байдал
- Цэвэр худалдан авалт
- Үндсэн тоноглолын найдвартай ажиллагаа, ө.х зуухны болон турбины зогсолтын тоо.

БЗӨБЦТС-ний Гүйцэтгэлийн гэрээнд орсон үр дүнгийн сонгосон гол үзүүлэлтүүдэд:

- Цахилгаан түгээлтийн алдагдлыг багасгах
- Нийт авлагыг сайжруулах
- Нэг худалдан авагчид төлөх төлбөр
- Өглөг барагдуулах дундаж хугацааг сайжруулсан байдал орж байна.

Тусгай зөвшөөрөл бүхий компаниудын тарифын орлогын нийгмийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг үндэслэн 2008 оны жилийн эцэст үр дүнгийн гол үзүүлэлт тус бүрээр гүйцэтгэлийг дүгнэж санхүүгийн урамшуулал эсхүл хариуцлага тооцох мөнгөний хэмжээг тогтоох юм. Дарханы ДЦС-ын хувьд урамшуулал, хариуцлага тооцох хамгийн дээд хэмжээ нь тус бүр 306.2 сая төгрөг, БЗӨБЦТС-ний урамшуулал, хариуцлага тооцох хамгийн дээд хэмжээ нь 145.4 сая төгрөг, 133.3 сая төгрөг тус тус байна.

*Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал харуулсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.*